



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/143

Улаанбаатар хот

Налайх дүүргийн “Нарны Эрч” өрхийн
эрүүл мэндийн төвийн хөрөнгийг
данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 09 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тавилга, эд хогшлын дансанд бүртгэлтэй нийт 1,191,739.20 (нэг сая нэг зуун ерэн нэгэн мянга долоон зуун гучин есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг бусад хангамжийн материалын дансанд шилжүүлэн бүртгэхийг Налайх дүүргийн “Нарны Эрч” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Баатарсайхан)-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Налайх дүүргийн “Нарны Эрч” өрхийн эрүүл мэндийн төв (Б.Баатарсайхан)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюумаа* В.ОЮУМАА

